



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/5/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас:70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: С.Энхбаатар

Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Аодо. 02.27 № 213

танай _____-ны № _____-т

ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН
ДАРГА Л.НАРАНХҮҮ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжимт драмын театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөгжимт драмын театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөгжимт драмын театрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520157

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Л.Наранхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол хүний оюун сэтгэлгээний хөгжлийн эх сурвалж байж Үндэсний урлаг, соёлын шилдэг ололт, давтагдашгүй онцлогийг хамгаалах, хүн төрөлхтөний дэвшилтэд ололттой хослуулан баяжуулан хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх замаар улсынхаа соёл, урлагийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах”-д оршино.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын үйл ажиллагааг мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний өндөр түвшинд явуулах, төсөв төслийн, хандивын хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нийгмийн баталгааг хангах.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөгжимт драмын театр нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд CTS програм хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд 14 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны

жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 859,179.4 мянган төгрөгөөс тооцон 17,183.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд тайлант үеийн гүйцэтгэлээр материаллаг байдлын түвшинг 20,741.4 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,971.5 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	00.0	00.0
Авллага	00.0	00.0	00.0
Бараа материал	254,909.9	267,152.7	12,242.8
Үндсэн хөрөнгө	4,942,182.3	5,109,275.4	167,093.1
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-498,857.5	-646,221.9	-147,364.4
Нийт хөрөнгө	4,698,234.7	4,730,206.2	31,971.5
Өр төлбөр	00.0	00.0	00.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,698,234.7	4,730,206.2	31,971.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,698,234.7	4,730,206.2	31,971.5

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материал үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр засварын ажил хийгдсэн, улсын төсвийн хөрөнгөөр задгай тайз, техник хэрэгсэл, өөрийн төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсанаас шалтгаалжээ. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 23,996.5 мянган төгрөгийн засварын ажлыг капиталжуулж, улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 120,000.0 мянган төгрөг, өөрийн төсвөөр худалдан авсан 10,639.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 760.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,730,206.2 мянган төгрөг болж 31,971.5 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө оруулалт болон өөрийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 8 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын хувьд орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 786,742,5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 786,742.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 786,742.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөгджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 785,972.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсвийн хуваарийн дагуу зардлыг зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны орлогоос 70,108.0 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 120,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 23,996.6 мянган төгрөг, бусад орлогоос 21,800.7 мянган төгрөг, нийт 235,905.3 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ. Үүнээс хангамж, бараа материалын зардалд 4,950.0 мянган төгрөг, нормативт зардалд 1,780.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 172,463.3 мянган төгрөг, томилолтын зардалд 8,016.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 48,695.2 мянган төгрөг, нийт 235,905.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 эрсдэл тодорхойлж, нийт 15 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 54,054.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,149.4 мянган төгрөгийн 3 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 16,908.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, 23,996.5 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэлээ. Үүнд:

1. Мөнгөн кассын нярав нь бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгээгүй нь Сангийн Сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 7.2-д “мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж ... нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна.” гэж заасантай нийцэхгүй байна.
2. Тайлант хугацаанд хийсэн бараа материалын 13,149.4 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ..., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог;”, 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар

батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3. Жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийх тухай тушаал гаргаагүй, тооллого хийсэн дэлгэрэнгүй бүртгэлийг бүрэн хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 16,908.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Хөгжимт драмын театр Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.12. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөгжимт драмын театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. МУЕА-аас өгсөн чиглэлийн дагуу суудлын автомашины ашиглалтын талаар:
 - 1.1. Илрүүлэлт: Байгууллагын дарга нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй байхад тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр 3,000.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.
 - 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.
 - 1.3. Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.
 - 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно
2. Зардлын данстай холбоотой асуудал:
 - 2.1. Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын 13,908.1 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.
 - 2.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.
 - 2.3. Өгсөн зөвлөмж: Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөж ажиллах.
 - 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>254,909,901.00</u>	<u>267,152,695.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	254,909,901.00	267,152,695.00
351	Түүхий эд материал	149,120,227.00	147,819,320.00
35110	Тусгай зориулалттай материал	149,120,227.00	147,819,320.00
354	Хангамжийн материал	92,529,674.00	107,123,375.00
35410	Бичиг хэргийн материал	3,621,897.00	3,920,720.00
35420	Аж ахуйн материал	80,227,478.00	97,674,805.00
35470	Бусад хангамжийн материал	8,680,299.00	5,527,850.00
35600	Мал амьтад	13,260,000.00	8,880,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,443,324,807.97</u>	<u>4,463,053,540.64</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,443,324,807.97	4,463,053,540.64
392	Биет хөрөнгө	4,071,909,807.97	4,091,638,540.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,833,983,028.00	3,862,176,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 26,380,739.00	- 99,414,671.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,000,000.00	41,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 29,333,333.40	- 32,666,666.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	108,940,992.00	116,580,732.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 56,468,554.99	- 72,354,006.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	179,040,000.00	182,800,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 92,250,708.82	- 109,639,119.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	407,603,287.00	535,103,287.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	- 294,224,162.82	- 331,947,431.60
393	Биет бус хөрөнгө	371,415,000.00	371,415,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 200,000.00	- 200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	371,415,000.00	371,415,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,698,234,708.97</u>	<u>4,730,206,235.64</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,698,234,708.97</u>	<u>4,730,206,235.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,698,234,708.97	4,730,206,235.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,887,642,298.00	4,887,642,298.00
51101	Өмч: - төрийн	4,887,642,298.00	4,887,642,298.00
512	Хуримтлагдсан үр дүн	- 345,210,422.10	- 313,238,895.43
51210	Өмнөх үеийн үр дүн	- 345,210,422.10	- 345,210,422.10
51220	Тайлант үеийн үр дүн	-	31,971,526.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	155,802,833.07	155,802,833.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,698,234,708.97</u>	<u>4,730,206,235.64</u>

4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	825,844,100.00	1,045,047,290.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	111,786,400.00	871,750,040.00
120	Нийтлэг татварын бус орлого	39,986,400.00	80,510,650.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,986,400.00	80,510,650.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,435,900.00	70,108,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,550,500.00	10,402,650.00
121	Хөрөнгийн орлого	60,000,000.00	4,196,890.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	60,000,000.00	4,196,890.00
122	Тусламжийн орлого	11,800,000.00	300,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	11,800,000.00	300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	714,057,700.00	173,297,250.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	667,383,700.00	7,500,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	7,500,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	667,383,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,674,000.00	165,797,250.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,674,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,000,000.00	165,797,250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		786,742,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		786,742,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	859,179,439.36	1,013,075,763.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	859,179,439.36	1,013,075,763.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	848,074,180.36	1,002,439,697.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,482,511.00	630,275,925.00
210101	Үндсэн цалин	526,482,511.00	630,275,925.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,204,700.00	78,589,348.00
210201	Тэтгэврийн даатгал	63,204,700.00	55,768,151.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	4,563,999.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	5,705,299.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,141,301.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	11,410,598.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,990,975.00	26,435,321.00
210301	Гэрэл, цахилгаан	8,170,400.00	8,172,051.00
210302	Түлш, халаалт	18,820,575.00	14,435,999.00
210303	Цэвэр, бохир ус	-	3,827,271.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,461,705.00	17,852,514.00
210401	Бичиг хэрэг	3,056,593.00	931,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,000.00	952,900.00

210404	Ном, хэвлэл	-	496,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,825,112.00	3,845,928.00
210408	Бараа материал акталсны зардал	-	8,025,606.00
2105	Нормативт зардал	-	360,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,634,887.00	16,947,590.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,791,750.00	199,160.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	300,000.00
210604	Урсгал засвар	11,843,137.00	16,448,430.00
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	11,779,750.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	11,779,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,571,155.00	72,834,852.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,916,205.00	70,926,512.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	333,950.00	335,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,700.00	109,040.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	1,158,300.00	1,158,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,728,247.36	147,364,397.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,060,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	146,668,247.36	147,364,397.33
212	ТАТААС	130,000.00	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	130,000.00	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	130,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,975,259.00	10,636,066.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,012,600.00	9,866,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,800.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,250,000.00	4,380,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,760,800.00	4,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,962,659.00	770,066.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,962,659.00	770,066.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	- 33,335,339.36	31,971,526.67
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	- 33,335,339.36	31,971,526.67

4.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	745,493,600.00	1,022,647,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,435,900.00	856,850,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	31,435,900.00	70,108,000.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,435,900.00	70,108,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,435,900.00	70,108,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	786,742,500.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	-	786,742,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	714,057,700.00	165,797,250.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	667,383,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	667,383,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,674,000.00	165,797,250.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,674,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,000,000.00	165,797,250.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	745,493,600.00	1,022,647,750.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	745,493,600.00	1,022,647,750.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	736,770,141.00	1,016,391,684.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,482,511.00	630,275,925.00
210101	Үндсэн цалин	526,482,511.00	630,275,925.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,204,700.00	78,589,348.00
210201	Тэтгэврийн даатгал	42,136,600.00	53,440,852.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,213,600.00	5,029,459.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,267,100.00	6,287,124.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,053,300.00	1,257,666.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,534,100.00	12,574,247.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,990,975.00	26,435,321.00
210301	Гэрэл, цахилгаан	8,170,400.00	8,172,051.00
210302	Түлш, халаалт	14,999,549.00	14,435,999.00
210303	Цэвэр, бохир ус	3,821,026.00	3,827,271.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,618,905.00	11,027,500.00
210401	Бичиг хэрэг	3,199,593.00	1,024,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,000.00	952,900.00
210404	Ном, хэвлэл	-	2,140,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,839,312.00	3,310,000.00
2105	Нормативт зардал	-	1,780,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,780,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,084,100.00	178,463,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,429,900.00	127,832,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	300,000.00
210604	Урсгал засвар	11,654,200.00	50,330,400.00
2107	Томилот, зочны зардал	4,000,000.00	9,516,750.00
210702	Дотоод албан томилот	4,000,000.00	9,516,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,328,950.00	80,303,540.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,674,000.00	78,395,200.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	333,950.00	335,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,700.00	109,040.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	1,158,300.00	1,158,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,060,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,060,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,723,459.00	6,256,066.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,760,800.00	5,486,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,760,800.00	4,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,962,659.00	770,066.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,962,659.00	770,066.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	4,887,642,298.00	155,802,833.07	-345,210,422.10	-	4,698,234,708.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	31,971,526.67	-	31,971,526.67
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,887,642,298.00	155,802,833.07	-313,238,895.43	-	4,730,206,235.64

4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	786742500.00	785972434.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	786742500.00	785972434.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	781256500.00	780486434.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630364400.00	630275925.00
210101	Үндсэн цалин	630364400.00	630275925.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78795300.00	78589348.00
210201	Тэтгэврийн даатгал	53581000.00	53440852.00
210202	Тэтгэмжийн даатгал	5042400.00	5029459.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6303600.00	6287124.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1261200.00	1257666.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12607100.00	12574247.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26910000.00	26435321.00
210301	Гэрэл, цахилгаан	8400000.00	8172051.00
210302	Түлш, халаалт	14680000.00	14435999.00
210303	Цэвэр, бохир ус	3830000.00	3827271.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6077500.00	6077500.00
210401	Бичиг хэрэг	1024600.00	1024600.00
210402	Тээвэр, шатахуун	3600000.00	3600000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	952,900.00	952,900.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	6,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,800,000.00	2,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	2,900,000.00	2,900,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,609,300.00	31,608,340.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,700,000.00	29,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	335,000.00	335,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	109,040.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	1,158,300.00	1,158,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,486,000.00	5,486,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,486,000.00	5,486,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	4,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	- 770,066.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	- 770,066.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	- 770,066.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	79	79
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	63	63



Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620003	Үйлчлэх ажилтан	15	15
620004	Гэрээт ажилтан		